



ТӨРИЙН ӨМЧИЙН БОДЛОГО,
ЗОХИЦУУЛАЛТЫН ГАЗРЫН
ТОГТООЛ

2019 оны 12 сарын 10 өдөр

Дугаар 518

Улаанбаатар хот

Үндсэн хөрөнгө нээлттэй дуудлагын
худалдаагаар худалдах зөвшөөрөл
олгох тухай

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 8, 29 дүгээр зүйл, 31 дүгээр зүйлийн 1, 3 дахь хэсэг, Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2019 оны 268 дугаар тогтоолын 4.2, 4.3, 269 дүгээр тогтоолын 2, 3 дугаар заалтыг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1.Шинжлэх Ухааны Академийн Газар зүйн хүрээлэнгийн үндсэн хөрөнгөд бүртгэлтэй, элэгдлээрээ анхны өртгөө нөхсөн, цаашид сэргээн засварлаж ашиглах боломжгүй болсон нийт 28,226,124.00 (хорин найман сая хоёр зуун хорин зургаан мянга нэг зуун хорин дөрөв) төгрөгийн балансын үнэ бүхий 2 ширхэг автомашиныг нээлттэй дуудлагын худалдаагаар худалдахыг зөвшөөрч, худалдах доод үнийг хавсралтад заасны дагуу тогтоосугай.

2.Шинжлэх Ухааны Академийн ерөнхийлөгч Д.Рэгдэл, Шинжлэх Ухааны Академийн Газар зүйн хүрээлэнгийн захирал Б.Баттогтох нарт дор дурдсан арга хэмжээ авч ажиллахыг даалгасугай:

2.1.Байгууллагын өмч хамгаалах Байнгын зөвлөлийн хяналт дор хавсралтад заасан хөрөнгийг худалдах ажлыг холбогдох хууль тогтоомж, захиргааны актын дагуу зохион байгуулах;

2.2.Нээлттэй дуудлагын худалдаанаас олох орлогыг (дуудлагын худалдааны зардлыг хассан дүнгээр) зохих захиргааны актын дагуу улсын төсөвт төвлөрүүлэх;

2.3.Хөрөнгийн хөдлөлийг холбогдох хууль тогтоомж, журмын дагуу нягтлан бодох бүртгэл, тайланд тусган “Төрийн болон орон нутгийн өмчийн удирдлагыг мэдээлэлжүүлэх систем”-д бүртгэх;

2.4.Арга хэмжээний биелэлтийг 2020 оны 1 дүгээр улиралд багтаан ирүүлэх.

3.Энэ тогтоолын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Төрийн өмчийн бүртгэл, хяналтын хэлтэс (Ц.Түвшинзаяа)-т үүрэг болгосугай.


ДАРГА

З.МЭНДСАЙХАН

ЗАХИРГАА, ХУУЛЬ ЗҮЙН
ХЭЛТСИЙН ДАРГА

А.АРИУНБОЛД

0001061



Төрийн өмчийн бодлого зохицуулалтын
газрын 2019 оны 12 дугаар сарын 10-ны
өдрийн 5/4 дугаар тогтоолын хавсралт

ШИНЖЛЭХ УХААНЫ АКАДЕМИЙН ХАРЬЯА ГАЗАР ЗҮЙН ХҮРЭЭЛЭНГИЙН ҮНДСЭН ХӨРӨНГӨД БҮРТГЭЛТЭЙ,
НЭЭЛТТЭЙ ДУУДЛАГЫН ХУДАЛДААГААР ХУДАЛДАХ АВТОМАШИНЫ ЖАГСААЛТ

Д/д	Автомашини марк, улсын дугаар, зориулалт, арлын дугаар	Үйлдвэрлэсэн /ашиглалтад орсон он	Нийт гүйлт /км/	Балансын үнэ	Хуримтлагдсан элэгдэл	Үлдэгдэл өртөг	Сэргээн босголын зардал	Худалдах дээд үнийн санал
1	УАЗ Фургон, УБМ 67-69, суудлын арал:10004741	2001/2001	14,320	5,334,124.00	5,334,124.00	-	450,000.00	500,000.00
2	Хьюндай Старекс, УБМ 76-31, суудлын, арал: КМНJIVWH7HPSU624765	2004/2008	264,600	22,892,000.00	22,892,000.00	-	530,000.00	600,000.00
Нийт дүн				28,226,124.00	28,226,124.00	-	980,000.00	1,100,000.00
				(хорин найман сая хоёр зуун хорин зургаан мянга нэг зуун хорин дөрвөн)				(есөн зуун наян мянга)